



**НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/06

Улаанбаатар хот

**Баримт бичиг нягтлан шалгах
комисс томилох тухай**

Монгол улсын төрийн хяналт шалгалтын тухай хууль, Архивын тухай хуулийн 22 дугаар зүйл, “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”-ын 10.3 дахь хэсэг, тус газрын “Дотоод хяналт, баримт бичиг нягтлан шалгах журам”-ын 3.1.2 дахь заалт, 3.2 дахь хэсэг, газрын дүрмийн 5.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Баримт бичиг нягтлан шалгах комисс”-ыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга:

Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх хэлтсийн дарга – Н.Пүрэвсүрэн

Гишүүд:

Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга – Ц.Бямбасүрэн

Хүний нөөцийн мэргэжилтэн – Э.Энгүүн

2. Байгууллагын архивын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн акт, дүрэм журам, заавар, стандартын хэрэгжилтэд дүгнэлт хийж, байгууллагын хэмжээнд зөвлөмж өгөх, үйл ажиллагааг сайжруулах талаар дэмжлэг үзүүлж, хяналт тавин ажиллахыг комиссын дарга /Н.Пүрэвсүрэн/-д үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан газрын даргын 2017 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/06 тоот тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА  С.БАТЖАРГАЛ

УЛААНБААТАР ХОТ
НАЛАЙХЫН БАРИЛГЫН
МАТЕРИАЛ ҮЙЛДВЭРЛЭЛ,
ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨААТҮГ
ТТБ8651 н.а. 5890683